



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025-02-12 № 05/3141
танай _____-ны № _____-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.ОЮУНБОЛД
ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Дотоод аудитын албаны даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Дашдоржийн Баярдорж, Захиргаа, санхүүгийн хэлтсийн тооцооны нягтлан бодогчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Тогоонтөмөрийн Эрдэнэцэцэг нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

Харин Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн тооцооны нягтлан бодогчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Ж.Болормаа, Б.Батсүх нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг цахим системд бүртгэгдэж баталгаажаагүй байх тул хянан үзэх боломжгүй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР Т.ЭНХБОЛД



142503003592